



О.БАЯРЖАРГАЛ
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Нийгмийн
ажлын тэнхимийн багш,
ахлах дэслэгч

ШИНЭЭР ИРСЭН ЯЛТАНД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ГАДААДЫН ОРНУУДЫН ТУРШЛАГА

Түүхэн хугацааны туршид гяндан, шорон, колони, хорих анги хэмээн нэрлэгдэж ирсэн байгууллагад шинээр хорих ял эдлэхээр ирсэн хоригдогчдын хувьд хорих ангид ямар орчин нөхцөл хүлээж байгаа бол, албаны болон ялтны зүгээс харилцах харилцаа ямар байх бол, ард үлдсэн амьдрал хэрхэх бол гэх мэт олон бэрхшээлтэй тулгардаг тиймээс энэ асуудлыг шийдвэрлэх мэргэжилтэн шаардлагатай төдийгүй хорих байгууллагын нийгмийн ажил цаг үеэ даган хэрэгцээ шаардлага нь өсөн нэмэгдсээр байна. Мөн ялтныг хорих ангид ирсэн цагаас суллагдан гартал нийгмийн ажлын үйлчилгээг тасралтгүй хүргэх нь чухал бөгөөд үүнийг энэхүү илтгэлийн хүрээнд гадааддын зарим орны туршлагуудыг харьцуулан авч үзлээ:

Швейцарийн хорих

байгууллага дахь нийгмийн ажил

Швейцарийн хорих байгууллагын нийгмийн ажил нь дотроосоо болон гаднаас гэсэн хоёр хэлбэрээр явагдах бөгөөд тэдний үйл ажиллагааны туйлын зорилго нь ял эдэлж байгаа хүмүүсийг дахиад хорих ангид эргэж

ирэхгүй байхаар хүмүүжүүлэхэд оршдог.

Швейцарийн хорих байгууллагын нийгмийн ажил хоёр төрлийн загвараар явагддаг.

Нэгдүгээр загвар:

Хүн амын нийгмийн асуудлыг бүхэлд нь хариуцсан ажилтнууд хоригдогчдыг давхар хариуцах буюу хорих ангид тогтмол ирж хоригдогчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэдэг хэлбэр юм. Энэ загварын сайн тал нь тухайн ажилтан хот, орон нутгийн нийгмийн асуудал эрхэлсэн байгууллага хүмүүстэй байнга харилцаж байх бололцоотой учраас хоригдогчдын нийгэмшилт, нийгэмд дасан зохицох талаарх үйл ажиллагаанд илүү үр дүнтэй байдаг.

Энэхүү нийгмийн ажлын төвлөрсөн бүтэц нь хувийн компани, олон нийтийн болон шашны байгууллага зэргийг хоригдогчдод туслуулахаар татан оролцуулахад ч илүү дөхөм байдаг. Жишээ нь Базель мужийн нийгмийн албанд хоригдогчидтой ажилладаг байнгын 5, түр 1 ажилтантай байх жишээтэй. Тэд өдөрт 500-600 үйлчлүүлэгчтэй ажиллах бөгөөд нийгмийн тусламжийн асуудал эрхэлсэн 4 хувийн байгууллагатай хамтран ажилладаг байна. Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгчиддээ дээд зэргийн итгэл хүлээлгэж нийгэмшүүлэх арга амжилттай хэрэгжиж байна. Ингэхдээ хоригдогчтой эхнээс нь авхуулаад гаран гартал нь, тэр тусмаа нэг ажилтан дагнан ажиллаж байнга уулзаж ярилцдаг байна.

Ердийн нөхцөлд хоригдол нийгмийн ажилтантай уулзах

хүсэлтийг хорихын захиргаагаар уламжлан тавих ба гадуур ажилладаг нийгмийн ажилтан нь 10 хоногийн дотор ирж уулзан тулгарсан асуудлыг хамтран шийдвэрлэх төлөвлөгөө гаргаж ажилладаг.

Нийгмийн албаны үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад ажилтнуудын сонголтыг зөв хийх нь чухал ач холбогдолтой. Нийгмийн албанд дээд болон тусгай дунд боловсролтой, мэргэжлийн дагуу нэмэлт сургалт хийсэн буюу ажиллаж байх хугацаандаа гурван жилийн сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд ажилладаг. Түүнчлэн урьд өмнө ял шийтгэл хүлээж байгаагүй хүмүүс ажиллах шаардлага тавигддаг.

Хоёрдугаар загвар

Асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг. Мөн хоригдогчдын байгаа газраар явж ажиллана. Хоригдогчдыг анх ирж карантинд 2-3 сар байхад нь нэг бүрчлэн уулзаж тэднийг судалдаг байна. Швейцарьт 600 хоригдолтой ангид 5-6 нийгмийн ажилтан буюу нэг ажилтанд 60-80 үйлчлүүлэгч ноогддог.

Нийгмийн ажилтны албан үүрэгт шинээр ирсэн ялтанд үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

1. Хоригдогчийг судалж дүгнэлт хийх, түүний нийгмийн хэлхээ холбоо, нийгмийн хэм хэмжээг зөрчсөн байдал, тулгамдсан асуудал, нийгмийн бэрхшээлүүдийг судлах,

2. Түүний нийгмийн асуудлыг ял эдлэх хугацаанд шийдвэрлэх төлөвлөгөөг хамтран гаргах,

3. Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж шаардлагатай туслалцаа үзүүлэх,

4. Хоригдогчтой холбогдолтой бүхий л баримт бичгийн бүрдлийг хөтлөх (сайшаал, шийтгэл гэх мэт),

5. Хоригдлын гэр бүл, санхүү, эд хөрөнгө, тэтгэврийн зэрэг асуудлыг шийдвэрлэх,

6. Ар гэрийнхэнтэй нь холбоо бариулах, ажил, соёл, спортын арга хэмжээг зохион байгуулах,

Нийгмийн ажилтан хоригдогчийн зөвхөн өөрөө хүсэлт тавьсны дагуу үйл ажиллагаа явуулдаг, нэг үгээр хэлбэл шаардлага гарсан үед ажилладаг гэсэн үг юм.

АНУ-ын хорих байгууллагын нийгмийн ажил

АНУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагууд нэг талаас хууль зүйн сайд, нөгөө талаас тухайн оршин буй нутаг дэвсгэрийн засаг захиргаанд давхар харьяа-лагддаг. АНУ-д дараах гурван төрлийн хорих байдаг.

1. Дээд зэргийн хамгаалалтын түвшинтэй буюу хоригдлууд бусдаас, түүний дотор албан хаагчдаас тусгаарлагдсан.

2. Хамгаалалтын дунд түвшний буюу хоригдлууд хорих дотроо салхинд гарах, номын сан, усанд орох газар зэрэгт очих боломжтой.

3. Хамгаалалтын хялбаршуулсан түвшний хорих буюу хоригдлууд нэгдсэн байранд байрлаж хорих дотроо бараг чөлөөтэй явах боломжтой, гадна хашаа, торгүй.

Хамгаалалтын дунд болон хялбаршуулсан түвшнийхэн нийгмийн

ажилтан, өмгөөлөгч, сэтгэл мэдрэлийн эмчийн туслалцааг авч болох бөгөөд дунд сургуулийн болон их сургуулийн хөтөлбөрөөр боловсрол эзэмших, мэргэжил эзэмших сургалтанд хамрагдах, согтуурах болон мансуурлын хамаарлаас гарах эмчилгээ хийлгэх, шашны зан үйл гүйцэтгэх боломжтой.

АНУ-д нийгмийн ажилтан сэжигтнийг урьдчилан хорих байгууллагад байхад нь ажиллаж эхлэх бөгөөд шүүхийн даалгавраар тухайн хүний талаар болон ойр дотных нь хүмүүсийн тухай лавлагаа бэлтгэж, шүүх хуралд танилцуулна. Энэ мэдээлэл шүүх хурлын явцад болон тухайн хоригдолтой цаашид ажиллахад хэрэгтэй зүйл болдог.

Хорих байгууллага дахь нийгмийн ажлын зорилго нь хоригдогч бодит байдлыг сайтар ойлгож хувь заяагаа өөрчлөх шаардлагатайг мэдрүүлэхэд оршино. Үүний тулд хоригдогчтой үр ашигтай агуулга бүхий харилцаа тогтоож, зөв оношлон ажиллах бэлтгэл хийх хэрэгтэй.

Хорихын доторх төрөл бүрийн гаж үзэгдлээс хоригдогчийг сэргийлэх, шаардлагатай үед түүнд туслах үүргийг нийгмийн ажилтан гүйцэтгэнэ. Мөн хоригдогчийн ар гэртэй ажиллах, гэр бүлд тулгамдсан сэтгэл зүйн асуудлууд, нийгмийн болон эдийн засгийн асуудлыг даван туулахад тэдэнд туслахад нийгмийн ажилтан чухал үүрэгтэй.

АНУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад гэмт хэргийг бууруулахад чиглэсэн олон хөтөлбөр байдаг бөгөөд түүнийг

хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтан шууд оролцоотой. Хоригдогчийг ирэнгүүт бусад ажилтны хамт хүн тус бүрээр судалж нэг бүрчлэн ажиллах хөтөлбөр боловсруулдаг. Тухайлбал:

1. Сэтгэл зүйн хөтөлбөр – шийтгэгдсэн ялаа үндэслэлгүй гэх буюу үүнээс хөнгөн ял авах байсан гэж үзэх, эсхүл ялын хугацаа богиноос бусад хөтөлбөрт оролцох хугацаа хүрэлцэхгүй хүмүүс хамрагдана.

2. Эрчимжүүлсэн буюу удаан хугацааны хөтөлбөр – бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, давтан гэмт хэрэгтэн, мансууруулах бодис хэрэглэгчид хамрагдана.

3. Дамжлагын хөтөлбөр – суллагдахад 9 сар үлдээд байгаа хүмүүс хамрагдана.

4. Өргөтгөсөн хөтөлбөр – Оюуны хомсдолтой хүмүүст зориулагдсан болно.

АНУ-д сүүлийн үед эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарлах, тухайлбал хорих байгууллагаас гадуур байж сурч, ажиллахаа хэвийн үргэлжүүлэх шийтгэлийн хэлбэр нэлээд түгээмэл болж байгаа бөгөөд үүнд нийгмийн ажилтны оролцоо чухал аж.

АНУ-ын хувьд нийгмийн ажилтан шүүхэд ч, хорих байгууллагад ч, мөн туршилтын хугацаанд ч байнга оролцоотой байгаа нь тухайн хоригдогчдын засрал хүмүүжилд хяналттай, тасралтгүй нөлөөлөх, хорихын өмнөх болон суллагдсны дараа ч гэсэн хараа хяналттай байлгадаг туршлагатай.

**Германы хорих байгууллага дахь
нийгмийн ажил**

Германы шийдвэр гүйцэтгэлийн хууль тогтоомж нь хоригдлыг нийгмийн өмнө хариуцлага хүлээхүйц нийгэмшүүлэхээр засан хүмүүжүүлэх зорилго агуулсан байна. Энэ зорилтын үндсэн ачааллыг хорих байгууллагын нийгмийн алба үүрдэг. Иймээс Хууль зүйн яамнаас хорих байгууллагуудад нийгмийн ажилтан, лам, сэтгэл зүйч ажилладаг байна.

Нийгмийн ажилтан нь хорих байгууллага болон нийгмийн хооронд орших амьд гүүр болдог байна.

Нийгмийн ажилтнууд хоригдогчдыг анх ирэхэд захиргааны зүгээс хамгийн түрүүнд уулздаг бөгөөд ар гэртэй нь холбоо барих, ямар нэгэн асуудал байвал түүнийг шийдвэрлэж өгөхийг санал болгодог. Тэдний үйл ажиллагааны нэг үндсэн зарчим бол өнөөгийн хоригдол хэзээ нэгэн цагт нийгэмд эргэн орж бүрэн эрхт гишүүн болно гэдгийг ухамсарлаж байдаг оршдог.

Германы хорих байгууллагын нийгмийн албанд нийгмийн ажилтан, сурган хүмүүжүүлэгч багтдаг бөгөөд энэ алба нь тус байгууллагын салшгүй хэсэг юм. Тус албаны үйл ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэлийн хууль тогтоомжийн хэм хэмжээгээр зохицуулагддаг. Герман улсад нэг нийгмийн ажилтанд 70-80 хоригдол байхаар зохицуулагдсан. Нийгмийн ажилтны тоо багш, эмч, сэтгэл зүйчийн тооноос 2,5 дахин, санваартнуудын тооноос 4 дахин илүү байхаар зохицуулагдсан байна. Эдгээр мэргэжилтнүүд нийгмийн штаб буюу албанд багтдаг бөгөөд аюулгүй байдал

болон дэглэмийн гэсэн албадтай зэрэгцэн ажилладаг.

Германы хорих байгууллагын нийгмийн ажлын зохион байгуулалтад хэд хэдэн онцлог байдаг. Тухайлбал, шашны үүрэг нэлээд их байдаг. Хорих байгууллага бүрт католик юмуу протестант шашны санваартнууд хоригдлуудтай ажилладаг ба бүр суллагдсаны дараа нь хүртэл холбоотой байдаг байна.¹²⁵

Хоригдогчдыг хорих ангид ял эдлэх хугацаанд хэд хэдэн үе шатанд хуваан авч үздэг.

Нэгдүгээрт: Хорих байгууллагын нөхцөлд дасах үе

Хоёрдугаарт: Засран хүмүүжих

Гуравдугаарт: Суллагдахад бэлтгэгдэх

Ял эдлэх бүхий л үе шатанд тэднийг нийгмийн ажилтан судалж үе шат бүрт төлөвлөгөө гарган ажиллаж дүгнэж байдаг. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдах зүйл нь:

1. Хаалттай болон нээлттэй хорихын аль нөхцөлд байх
2. Эн тэнцүү харьцаа бүхий хэсэгт бусадтай хамт байх эсэх
3. Ажил хийх, мэргэжил эзэмших, мэргэшил дээшлүүлэх болон давтан бэлтгэхэд хамрагдах
4. Ерөнхий боловсролын мэдлэгээ дээшлүүлэх
5. Тусгайлсан тусламж үзүүлэх
6. Ял эдлэх нөхцлийг хөнгөрүүлэх
7. Суллагдахад бэлтгэх шаардлагатай ажил гүйцэтгэх.

¹²⁵ Лузгин С. А., Кузнецов М. И., Казанцев Б. Н. “Хорих байгууллагын нийгмийн ажил” УБ 2009 он

Хоригдогчийн өөрчлөлтийн байдал болон түүнийг судлах явцад гарч болзошгүй нэмэлт зүйлийг үндэслэн төлөвлөгөөг засварлаж болох бөгөөд ял эдлэх хугацааг харгалзан төлөвлөх ёстой.

Хоригдол оршин сууж байгаа байрандаа өөрийн эд зүйлээ зохих хязгаартайгаар байрлуулах эрхтэй.

Ойр дотных нь хүмүүсийн гэрэл зураг, мөн өөрт нь чухал зүйлсийг байлгахыг зөвшөөрдөг. Энэ нь сэтгэл зүйн хувьд хоригдол нь хүнийхээ хувьд өөрийгөө хадгалан үлдэх, ар гэрийнхэнтэйгээ холбоотой байх зэргээр нийгмийн ажлын хувьд туйлын чухал зүйл юм.

Нийгмийн ажилтны үүрэг нь хоригдолд нийгмийн дэмжлэг үзүүлэхэд оршдог. Тухайлбал: Хоригдлуудад тулгараад байгаа нийгмийн асуудлыг гаргаж тавих, хувь хүний тухайд болон хүмүүс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэх, харилцааны соёл, харилцан зөвшилцөл, тэвчээртэй байхыг хэвшүүлэх, нийгмийн тусламжийн эх үүсвэрийг эрж хайх, боловсрол олоход нь туслах гэх мэт. Энэ утгаараа нийгмийн ажилтан хоригдогчийг эхнээсээ аваад ялаа дуусан дуустал хамт явна гэсэн үг юм.

Францын хорих байгууллагын нийгмийн ажил

Шинээр ирсэн ялтныг ирсэн өдөр нь хүлээн авч эмчийн үзлэгт оруулан, үзлэг нэгжлэг хийж холбогдох анкетыг бүрдүүлдэг. Энэ нь тухайн ялтныг сэтгэл зүйн хямралыг үүсгэдэг гэж үзэн хямралыг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ирснийх нь маргааш

нийгмийн ажилтан ярилцлага хийдэг. Мөн гэр бүлийн мэдээллийг авч, хэзээ яаж уулзах болон зөвшөөрөгдсөн эд зүйлсийг нь танилцуулдаг байна. Долоо хоног тусгаарлах байранд байлгаад өрөөнд хувиарлана.

Нийгмийн ажлын алба нь шинээр ирсэн ялтныг долоо хоног ажиглаад сэтгэл зүйн болон орчны ямар дэмжлэг хэрэгтэй байгаа талаар ярилцаж төлөвлөгөө гаргаж ажилладаг байна. Үйлчлүүлэгч өөрөө нийгмийн ажилтнаас дэмжлэг авах, уулзахыг хүсэхгүй тохиолдолд хорих ангиас гарах хүртэл нь үйлчилгээ үзүүлэхгүй ч байж болдог байна. Нэг нийгмийн ажилтан 90-150 ялантай ажилладаг байна.

Дүгнэлт

Гадаадын зарим орны хорих байгууллагад явуулах нийгмийн ажлын бүхий л арга, хэлбэр нь тэдэнд зан үйлийн болон сэтгэл зүйн нөхөн сэргээлт явуулах, хорих байгууллагад дасан зохицох, нийгмийн амьдралд бие даан оролцох, гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байхад чиглэгдэж, энэ ажилд ялтны гэр бүлийн гишүүд, найз нөхөд, асрамжийн болон нийгмийн халамжийн, шашны, боловсролын, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллагууд, түүнчлэн хууль сахиулах зэрэг төрийн болон төрийн бус, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг чухалчлан үздэг байна.

Бусад улс орны туршлагаас харахад шинээр ирсэн ялтанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд ялтныг хүлээн авах үйл ажиллагаа, ялтныг байрлуулах, зөвшөөрөгдөх эд зүйлсийн

жагсаалт зэрэг нь манайд хийгддэг үйл ажиллагаатай холбоотой ижил төстэй асуудлууд нэлээдгүй байна. Тухайлбал: Ялтанд зөвшөөрөх эд зүйлсд боловсруулсан хүнсний болон гурилан бүтээгдэхүүн, ариун цэврийн болон ахуйн хэрэгцээний зүйлс, бугуйн цаг, аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад сонин, ном, сэтгүүл, нормын болон ээлжийн дотуур хувцас, спортын хувцас, хөлөгт, тоглоом, гэр бүлийн гишүүдийн гэрэл зураг, засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний бэлэн мөнгө зэрэг нь ижил төстэй зүйлийг эрх зүйн актуудаар зохицуулсан нь ажиллагдаж байна.

Харин шинээр ирсэн ялтны орчны нөлөөллөөс үүсэх сэтгэл зүйн хямрал, тэдний ар гэрийнхний сэтгэл зүйн таагүй байдал, тасралтгүй үргэлжлэх харилцаа холбоог нь хадгалах талаар анхаарал хандуулан ажиллах нь илүү чухал. Мөн орон нутгийн болон засаг захиргааны байгууллага, итгэл үнэмшлээр нь дамжуулан шашны байгууллагуудын оролцоо хорих байгууллагын нийгмийн ажлын үндсэн үйл ажиллагаанд сууж өгсөн байна. Тэд зөвхөн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг орчин нөхцөл нь ч тийм байдлаар хангагдсан, нэг нийгмийн ажилтанд оногдох жишиг норматив нь харьцангуй цөөн байгаагаараа давуу талтай байна.

Ашигласан материал:

1. ШШГЕГ-ын даргын 2010 оны А/107 дугаар тушаалаар батласан “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх

албаны нийгмийн ажилтны ажлын заавар”

2. Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/230 дугаар тушаалаар батласан “Хорих ангийн дотоод журам”

3. Лузгин С.А, Кузнецов М.И, Казанцев Б.Н “Хорих байгууллагын нийгмийн ажил” УБ., 2009 он

4. Мягмар.О “Хувийн дасан зохицохуй” УБ., 2000 он

5. Мягмар.О “Сэтгэл судлал” УБ., 2007 он

6. Мягмар.О “Судлаач багшийн гарын авлага” УБ., 2009 он

7. Нямдорж.Н, Түмэннаст.Г, Мягмарсүрэн.Б “Нийгмийн ажлын сургалтын гарын авлага” УБ., 2006 он